



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
АРВАЙХЭЭР СУМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 02 сарын 09 өдөр

Дугаар 10

Арвайхээр

Согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх иргэн, аж ахуйн нэгжид тусгай зөвшөөрөл олгуулахаар уламжлах тухай

“Архидан согтууруулахтай тэмцэх тухай” хуулийн 4.3 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цэгийн талаар авах арга хэмжээ-ний тухай 2015 оны 72 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ИТХурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Тус сумын 1-10 дугаар багийн 13 худалдааны газар, 3 баар, кафе нийт 17 цэгийн орчимд оршин амьдардаг 50 иргэнээс авсан сонгон шалгаруулах санал асуулгаар 60%-иас дээш саналаар дэмжигдсэн. Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага хангасан 13 худалдаа, 3 баар, кафе нийт 16 цэгт зөвшөөрөл олгуулахаар уламжилсугай.

2. Согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх иргэн, ахуйн нэгжид хуулийн хэрэгжилтийг мөрдүүлэн, хяналт тавьж ажиллахыг сумын Засаг дарга бөгөөд хотын Захирагч /О.Пүрэвдорж/-д үүрэг болгосугай.

ДАРГА  Д.АМАРТҮВШИН

